

Summary Information


ASX Ticker: **HUN**



Өсөх боломжтой

Ханш (3/10/2011)	A\$1.36
Зах зээлийн үнэлгээ: (A\$ сая)	\$247.5
Зах зээлийн үнэлгээ: (US\$ сая)	\$248.2
52 долоо хоногийн өндөр (A\$)	\$1.45
52 долоо хоногийн бага (A\$)	\$0.45
Зарласан хувьцааны тоо (сая)	182.6
Арилжааны дундаж (3 сар; сая ш)	1.07

Хувьцааны ханшийн өөрчлөлт



Хүннү коал

“Хүннү коал” нь 2010 оны хоёрдугаар сарын 12-нд Австралийн бирж дээр бүртгэгдсэн бөгөөд IPO нь оны шилдгээр шалгарсан компани юм. Компанийн хувьцаа нь HUN кодтой арилжаалагдаж байна.


Бид тус компанийн хувьцаанд үнэлгээ хийсэн эхний судалгаагаа Та бүхэнд танилцуулж байна. Судалгааны үр дүнд хувьцааны үнийг өсөх боломжтой гэж үзэж байна.

Компанийн тухай

“Хүннү коал” нь Монгол дахь үйл ажиллагаагаа өөрийн охин компани “Хүннү ресурс”-ээр дамжуулан явуулдаг. “Хүннү коал” нь коксжих ба эрчим хүчний нүүрсний 10 гаруй төсөлтэй. Нийтдээ JORC стандартын шаардлагыг хангасан 414 гаруй сая тонн нөөц баялаг тогтоогоод байгаа. Уг компанийн хоёр гол төсөл болох Цант-Уул 90 сая, Үнст худаг 324 сая тоннын нөөц баялагтай. Цаашдын хайгуул ба өрөмдлөгийн ажлын явцад энэхүү нөөцийн хэмжээг өсөх бүрэн боломжтой гэж үзэж байгаа юм. Цант-Уул коксжих нүүрсний төсөлдөө ашиглалтын лиценз авах гэж байгаа бөгөөд уг зөвшөөрлийг авснаар 2011 оны хоёрдугаар хагасаас нүүрс олборлож эхлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

“Хүннү коал” нь 2010 оны хоёрдугаар сард IPO хийснээр AU\$20 сая доллар босгожээ. IPO хийснээс хойш хувьцааны нэгж үнэ 580 хувиар өсөөд байна. 2011 оны гуравдугаар сарын 9-нд “Банпу минералс” компани “Хүннү коал”-ын 30 сая ширхэг хувьцааг A\$1.50 буюу нийт A\$45 сая доллараар худалдан авчээ. Энэ нь арилжаалагдаж байсан спот үнээс 21 хувиар илүү юм. Ингэснээр “Банпу минералс” нь “Хүннү коал” компанийн нийт хувьцааны 12.4 хувь буюу хамгийн том хувьцаа эзэмшигч болж байна.

Зураг 1: Хайгуулын ажлын зорилго, сая тонн



Эх үүсвэр: Компани

Гол үзүүлэлтүүд

- “Хүннү коал”-ын ордууд нь JORC стандартыг хангасан 414 сая тонн нөөц баялагтай. Эдгээр орд нь одоогийн болон төлөвлөгдөж буй дэд бүтцэд ойр оршдог.
- Цант-Уул коксжих нүүрсний төслийн ашиглалтын ажил эхэлсэн ба 2011 оны хагасаас олборлож эхлэх төлөвлөгөөтэй байна.
- 2011 оны дөрөвдүгээр улиралд багтаан Хонконгийн хөрөнгийн бирж дээр хувьцаагаа гаргахаар төлөвлөж байна.
- “Банпу минералс” нь “Хүннү коал”-ын 30 сая хувьцааг зах зээлийн үнээс 21 хувиар илүү үнээр худалдан авч, нийт А\$45 сая долларын хөрөнгө оруулснаар “Хүннү коал”-ын банкин дахь бэлэн мөнгө А\$75 сая доллар хүрсэн.
- “Хүннү коал” компанийн менежмент нь уул уурхайн салбарт олон жил ажилласан туршлагатай багаас бүрддэг.

Эрсдэл

Компанийн хувьцааны үнэд сөргөөр нөлөөлж болзошгүй гол эрсдэлүүд нь нүүрсний чанарын үзүүлэлтүүд хангалтгүй байх, Хятадын гангийн үйлдвэрлэл буурч, нүүрсний үнэ унах зэрэг байж болно.

Төсөл

“Хүннү коал” компани Монголд коксжих ба хүрэн нүүрсний 10 гаруй төсөлтэй. Одоогийн байдлаар ач холбогдол өгч буй хамгийн гол төслүүд нь Цант-Уул ба Үнст худаг юм.

Зураг 2: Hunnu Coal’s Projects

Төслийн Нэр	Байршил	Нүүрсний төрөл	Эзэмшдэг %	Товч тодорхойлолт	Хайгуулын Талбайн Хэмжээ
Үнст Худаг	Дундговь	Эрчим хүчний	80%	<ul style="list-style-type: none"> •2 хайгуулын, 1 олборлох лицензтэй (~1600га) •98.7 сая тонн нүүрс олборлох зөвшөөрөл авсан • Бүтээгдэхүүнийг нь урьдчилан худалдан авах (Офтейк) гэрээг Хятадын болон Монголын худалдан авагч нартай байгуулахаар ярилцаж байгаа. Цахилгаан станц барих асуудлыг хэлэлцэж эхэлсэн •Нүүрс газрын гадаргуугаас 4м гүнд байршсан, хөрс хуулалтын коэффициент 1:1-ээс бага •Шинэ орд- Хар Тойром •Монголын төмөр замаас 160км зайд оршдог 	59,000 га
Цант Уул	Өмнөговь	Коксжих	80%-90%	<ul style="list-style-type: none"> •Дэд бүтцэд ойр оршдог, Хятадын хил рүү ачаа тээвэрлэхэд ашигладаг замд болон баригдахаар төлөвлөж буй төмөр замд ойрхон •Таван Толгой, Оюу Толгой, Ухаа Худаг зэрэг ордуудтай ойр байршсан 	69,000 га
Буян	Өмнөговь	Коксжих	60%	<ul style="list-style-type: none"> •Таван Толгой ордтой ойр оршдог, бусад нүүрс экспортлогчидтой ойрхон •Одоогийн буюу баригдахаар төлөвлөж буй дэд бүтцэд ойр байршдаг 	76 га
Тэнүүн-2	Өмнөговь	Эрчим хүчний	60%	<ul style="list-style-type: none"> •Төслийн зүүн ба баруун-хойд талбайд гол анхаарлаа хандуулж байгаа •Өрөмдлөг болон геофизикийн ажил хийгдэх төлөвлөгөөтэй байгаа 	30,360 га
Цохио	Өмнөговь	Коксжих	60%	<ul style="list-style-type: none"> •Коксжих ба эрчим хүчний нүүрсний сайн ирээдүйтэй хэмээн таамаглаж буй төсөл •Нүүрсний судлын гарш нь ойролцоогоор 3км сунаж, 5 метрийн өргөнтэй судалтай огтлолцжээ 	38,600 га
Хүрээ-2	Өмнөговь	Коксжих/ Эрчим хүчний	60%	<ul style="list-style-type: none"> • Хайгуулын ажил: 14 суваг малталт, 230 метрийн өрөмдлөгийг 2 өрмийн цооногт хийсэн • Геологийн зураглал ба геофизикийн ажил хийх төлөвлөгөөтэй байгаа 	28,823 га
Цагаан Дэлгэр	Өмнөговь	Эрчим хүчний	85%	<ul style="list-style-type: none"> •Багахан хэмжээний хайгуулын ажил хийгдсэн эхний үе шатанд явж байгаа төсөл 	10,454 га
Дэлгэрэн	Дундговь	Эрчим хүчний	85%	<ul style="list-style-type: none"> •Багахан хэмжээний хайгуулын ажил хийгдсэн эхний үе шатанд явж байгаа төсөл 	10,943 га
Ар Зүүн Гол/Зүүн Гол	Бусад	Коксжих	70%	<ul style="list-style-type: none"> •Зэргэлдээ орших 2 лицензтэй (7854X and 10306X) •2011 оны эцсээр JORC стандартыг хангах нүүрсний нөөц батлуулах өрөмдлөг, модел ба судалгааны ажил хийжээр төлөвлөсөн 	25,640 га
Сүхбаатар	Бусад	Эрчим хүчний	60%	<ul style="list-style-type: none"> •Хайгуулын 3 лицензтэй – Мөнх Хаан, Нарийн, Хавцал 	36,233 га

Эх үүсвэр: Компани

Цант-Уул

Цант-Уул орд нь Өмнөговь аймагт оршдог. Тавантолгойн нүүрсний ордоос 40 км зайтай байрладаг. Уг орд нь 69,000 га талбайг эзэлдэг. “Хүннү коал” нь Цант-Уул төслийн 90 хувийг эзэмшдэг.

2011 оны хоёрдугаар сарын байдлаар Цант-Уул төсөл дээр 187 цооног өрөмдөж, нийтдээ 28,029 тууш метр өрөмдлөгийн ажил хийгдсэн байна. 5 өрөмдлөгийн цооногийн шинжилгээний үр дүнд нүүрсний чанар дараах байдлаар тогтоогджээ.

Зураг 3: Цант-Уул ордын нүүрсний чанар (2-р сарын 7, 2011).

Чийгшил	Үнслэг	Дэгдэмхий чанар	Хүхэр	Илчлэг (кКал/кг)
3.99%-6.51%	17.54%-39.01%	22.02%-42.44%	0.28%-0.65%	7,008-7,455

Эх үүсвэр: Компани

Мөн хоёрдугаар сард хийсэн өрөмдлөгийн ажлын үр дүнд нүүрсний угаагдах чанарыг тодорхойлохоос гадна металлургийн туршилт хийх зорилгоор Хятад болон Австрали улсын лабораториудад нүүрсний дээж явуулах болно. Бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд зориулсан дээжийг мөн энэхүү өрөмдлөгийн ажлаас авах юм.

Бид компанийн удирдлагатай ярилцаж, дараах мэдээллийг авсан болно:

- Цант-Уул уурхай ашиглалтад орсноор 3 жилийн дотор 10 сая тонн нүүрс олборлох төлөвлөгөөтэй байгаа. Жилийн олборлолт ойролцоогоор 1.5-3 сая тонн байх болно
- Олборлосон нүүрсийг уурхайн амнаас нийлүүлэх боломжтой
- Хөрс хуулалтын коэффициент 3:1
- Урдчилсан тооцоогоор олборлолтын зардал нь \$15-\$20/т байна.


Үнст худаг

Үнст худаг орд нь Дундговь аймагт оршдог. Төмөр замаас 180 км зайд орших ба нийт 59,000 га талбайтай.

“Хүннү коал” нь Үнст худагийн ордоос зүүн хойд хэсэгт орших Хар Тойромын шинэ ордод гол анхаарлаа тавьж ажилласан. Тус ордын JORC стандартыг хангах нөөц нь нийт 324 сая тонн ба 140 м гүнд 58.9 м хүртэлх зузаантай нүүрсний давхарга илэрчээ. Үнст худаг ордын 324 сая тонн нөөцийн 226 сая тонн нь нөөц баялгийн хувьд Хэмжигдсэн ба Тогтоодсон ангиллын нүүрс юм.

Уурхайн төлөвлөгөө, ТЭЗҮ, Байгаль орчинд нөлөөлөх судалгаа зэрэг нь батлагдсан. Түүнчлэн Хятадын Эрээн хот хилийн боомтоор тээвэрлэлт хийх нь тохиромжтой хэмээн үзэж тээвэрлэлтийн судалгаа явуулсан ба төлөвлөгөөний ажлууд дуусах шатандаа явж байна.

Зураг 4: Үнст худаг төсөл дээр хийсэн өрөмдлөгийн цооног



Эх үүсвэр: Компани

Тэнүүн-2

Тэнүүн-2 орд нь Өмнөговь аймагт оршдог ба 3,360 га талбайтай. Уг орд дээр өмнөх ажлаас илэрсэн нүүрсний давхаргууд дээр голлож ажиллахаас гадна шинээр өрөмдлөг хайгуулын ажил хийх болно.

Эхний судалгаагаар уг орд нь сайн чанарын эрчим хүчний нүүрс тэй болох нь тогтоогдоод байна.

Говь-Алтай дахь коксжих нүүрсний төслүүд

Говь-Алтайн төслүүд болох Ар зүүн гол/Зүүн гол нь 25,640 га газар эзэлдэг ба Хятадын хилээс ойролцоогоор 300 км зайтай оршдог. Уг төсөл дээр “Хүннү коал” 150-250 сая тонн нүүрсний нөөц баялаг тогтоохыг зорьж, хайгуулын ажил явуулж байна. 2011 онд томоохон өрөмдлөгийн ажил явуулахаар төлөвлөөд байгаа бөгөөд бид энэхүү төслийг “Хүннү коал”-ын коксжих нүүрсний нэг гол орд болно гэж таамаглаж байна.

Нөөц

Одоогийн байдлаар Цант-Уулын коксжих нүүрсний нөөц нь бусад компанийн коксжих нүүрсний нөөцтэй харьцуулахад бага байна. JORC стандартыг хангасан компаниуд дундаас “Монголиан майнинг корпораци” хамгийн их нөөцтэй. Нийт 499.9 сая тонн Хэмжигдсэн ба Тогтоогдсон нөөцтэй. Бид “Хүннү Коал”-ыг одоогоор нүүрс олборлож байгаа компаниудаас “Саусгоби Ресурс”-тэй төстэй хэмээн үзэж байна. Тус компани нь нийт 300 сая тонноос давсан нөөцтэй нь тогтоогдсон. Үйл ажиллагаа нь хайгуулын шатандаа явж байгаа компаниудаас “Эспайр майнинг” 330.7 гаруй сая тонн нүүрсний нөөцтэй нь илэрсэн. Одоогийн байдлаар Цант-Уул ордын нөөц нь бусад нүүрсний компаниудын харьцуулахад харьцангуй бага боловч цаашид хийх хайгуулын ажил нөөцийг нийлбэрээс нэмэгдүүлэх магадлалтай.

Зураг 5: JORC стандартыг хангасан нөөц, 2011 оны 2 дугаар сарын 7

Хэмжигдсэн (сая тонн)	Тогтоогдсон (сая тонн)	Таамагласан (сая тонн)	Нийт (сая тонн)
34.3	27.7	27.7	89.7

Эх үүсвэр: Компани, 2011 оны 2 сарын 7

Үнст худаг ордын JORC стандартын нөөцийн дүнг 2010 оны 12 дугаар сарын 3-нд олон нийтэд зарласан.

Зураг 6: JORC стандартыг хангасан нөөц 2010 оны 12 дугаар сарын 3


Хэмжигдсэн (сая тонн)	Тогтоогдсон (сая тонн)	Таамагласан (сая тонн)	Нийт (сая тонн)
18.85	207.4	98	324

Эх үүсвэр: Компани, 2010 оны 12 сарын 3

Дэд бүтэц ба тээвэрлэлт

Монголын уул уурхайг хөгжүүлэхэд нэн тэргүүнд шийдвэрлэх асуудал нь дэд бүтэц юм. Дэд бүтэц хязгаарагдмал өнөөгийн нөхцөлд эрдэс баялгийн ордуудын байршил чухал ач холбогдолтой билээ. “Хүннү коал” компанийн нүүрсний төслүүд нь байршлын хувьд одоогийн болон Монгол улсын Засгийн газраас байгуулахаар төлөвлөж буй авто замын сүлжээ, төмөр замд ойр оршдог тул Хятадын зах зээлд бүтээгдэхүүнээ нийлүүлэхэд тохиромжтой юм. Монголын нүүрсний гол давуу тал нь Хятадын зах зээлд нэн ойр байршил билээ. Тийм ч учраас “Хүннү коал”-ын Цант-Уул, Үнст худагийн ордууд Хятадын хил рүү баригдах авто ба төмөр замд ойр байснаар тээврийн зардал нь бага байх болно. Монголын нүүрсний зах зээл дэх өрсөлдөгч компаниудтай харьцуулахад “Монголиан майнинг корпораци”-ийн тээврийн зардал хоёр дахин бага байгаа нь байршлын давуу талыг харуулсан тод жишээ болж байна.

Зураг 7: Төслийн байршил



Эх үүсвэр: Компани

Монгол улсын Засгийн газраас уул уурхайн хөгжлийг дэмжих ажлын хүрээнд барихаар төлөвлөсөн Тавантолгой-Зүүнбаянгийн төмөр замаас Цант-Уул орд нь холгүй оршдог. Мөн Ухаахудаг-Гашуунсухайтын төмөр зам тавигдах үед ашиглах бүрэн боломжтой нь давуу тал юм. Үнст худагийн орд нь Монголын ба Хятадын зах зээлд Тавантолгой-Зүүнбаянгийн чиглэлээр нэвтрэх боломжтой.

2011 оны хоёрдугаар сарын 11-нд төмөр зам барих ажлын анхны зөвшөөрлийг “Монголын төмөр зам” төрийн өмчит компанид өгснөөр зам тавих ажил 2011 оны эхний хагаст эхлэхээр болсон билээ. Одоогоор Хятадын хилийн боомт руу Гашуунсухайт болон Нарийнсухайтын чиглэлээс тавих төмөр замын ажил хэзээ эхлэх нь тодорхойгүй байгаа ч Тавантолгойн анхны төмөр замын ажил эхэлснээр хоёрдугаар шатны төслүүд хэрэгжих нь дөхөм болж байна. (Доорх газрын зураг дээр төмөр замын төслийн үе шатуудыг харуулжээ)

Зураг 8: Одоогийн болон төлөвлөгдөж буй төмөр замын зураг




Эх үүсвэр: Зам Тээвэр, Барилга, Хот Байгуулалтын Яам

Хувьцааны ханшийн өөрчлөлт

“Хүннү коал” компани 2010 оны хоёрдугаар сард Австралийн бирж дээр хувьцаагаа гаргаж, A\$20 сая доллар амжилттай босгосон. Тус компанийн хувьцаа 2010 оны гуравдугаар сарын 10-ны байдлаар 580 хувиар өссөн байна. Гуравдугаар сарын 9-нд “Банпу минералс” тус компанийн 12.4 хувь буюу 30 сая ширхэг хувьцааг арилжаалагдаж байсан зах зээлийн үнээс 21 хувиар өндөр үнээр худалдаж авсан. Энэ гүйлгээ хийгдсэнээр компанийн банкин дахь бэлэн мөнгө A\$75 сая доллар болж, Цант-Уул төслөө олборлолтын үе шатанд шилжүүлэх, бусад төсөл дээр өрөмдлөгийн ажил явуулах хангалттай хөрөнгөтэй болжээ.

Зураг 9: Хувьцааны ханшийн өөрчлөлт



Эх үүсвэр: Google Finance

Хөрөнгө оруулалтын зөвлөмж

Бид энэ удаад “Хүннү коал” компанийн хувьцааг дараах үнэлгээн дээр тулгуурлаж **ӨСӨХ БОЛОМЖТОЙ** гэж тооцоолж байна:

- “Хүннү коал” нь ур чадвартай, туршлагатай, зорьсноо амжилттай биелүүлдэг менежментийн багтай компани юм.
- “Хүннү коал” нь төлөвлөгдсөн болон одоо байгаа дэд бүтэцтэй ойр, мөн Хятадын зах зээлд асар ойрхон байрлах JORC стандартаар тогтоогдсон 400 гаруй сая тоннын нөөц бүхий шилдэг хөрөнгөтэй компаниудын нэг юм.
- “Банпу минералс”-ын хөрөнгө оруулалт нь нь Цант-Уулын дэд бүтцийг өргөтгөх, уул уурхайн үйлдвэрлэлийн ажиллагааг эхлүүлж явуулах бололцоог олгож байгаа.
- Бид Монголын нүүрсний салбар хөгжинө гэдэгт итгэлтэй байна. Хятад улстай хөрш зэргэлдээ байрлах Монголын өндөр чанарын нүүрс нь дэлхийн хамгийн том олборлоогүй коксжих болон дулааны нүүрсний нэг бөгөөд Хятадын далайн чанадын импортыг маш хурдан өөрчилж байна.

Тус компанийн техник эдийн засгийн үндэслэл нь одоогоор бүрэн хийгдэж дуусаагүй байгаа тул бид энэ тайландаа үнийн судалгааг нарийвчлан оруулах боломжгүй байлаа.

Зураг 10: Харьцуулах шинжилгээ

Компани	Код	Зах зээлийн үнэлгээ (US\$ сая)	Компанийн үнэлгээ/Нөөц (US\$/t)	Компанийн үнэлгээ/Нөөц* (US\$/t)	P / 2011E	P / 2012E	Компанийн үнэлгээ/2011 EBITDA	Компанийн үнэлгээ/2012 EBITDA
Mongolian Mining Corp	HK:0976	\$4,832	9.55	16.70	18.59	14.23	10.52	6.34
Mongolia Energy Corp	HK:0276	\$1,416	11.67	17.41	NM	NM	NM	NM
SouthGobi Energy Resources	HK:1878	\$2,863	7.77	20.95	NM	33.61	30.69	12.13
Aspire Mining	ASX:AKM	\$375	1.13	NA	NA	NA	NA	NA
Hunnu Coal	ASX:HUN	\$248.24	0.56	NM	NM	NM	NM	NM
Xanadu Mines	ASX:XAM	\$94	0.29	NA	NA	NA	NA	NA
Average			5.16	18.36	18.59	23.92	20.60	9.24
Chinese peers								
Shenhua	HK:1088	\$87,320	4.98	11.71	13.14	11.75	7.26	6.46
China Coal	HK:1898	\$20,671	NM	3.54	11.23	9.26	5.82	4.80
Hidili	HK:1393	\$1,723	2.60	2.96	10.69	8.57	10.64	6.67
Yanzhou	HK:1171	\$15,089	7.59	6.55	10.87	10.23	7.24	6.73
Fushan	HK:0639	\$3,889	6.35	8.62	12.89	11.31	6.21	5.43
Average			5.38	6.68	11.76	10.23	7.43	6.02

Эх үүсвэр: MICC Судалгаа, Reuters, Thomson One

“Занаду майнс”, “Эспайр майнинг” болон “Хүннү коал” компаниуд нь гадаадын хөрөнгийн биржид бүртгэлтэй Монголд нүүрсний хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа шинэ залуу компаниуд юм. “Хүннү коал” нь үйлдвэрлэл явуулаагүй эдгээр компаниас дараах давуу талуудтай.

1. **Байршил.** Цант-Уул нүүрсний төсөл нь Хятад руу тээвэрлэлт хийх гарцаас ойролцоогоор 5 км, Тавантолгойн уурхайгаас 40 км зайд оршдог. Ирээдүйд уг төсөл нь “Монголиан майнинг корпораци”-ийн Ухаахудаг төсөл болон Тавантолгойн уурхайн дэд бүтцийн өргөтгөлд хамрагдах ашигтай байрлалтай.
2. **2011 онд төлөвлөгдсөн олборлолт.** “Хүннү коал” компани нь Цант-Уул төслийнхөө олборлолтын үйл ажиллагааг 2011 оны сүүлийн хагас жилд хийхээр төлөвлөж байгаа бөгөөд ашиглалтын лицензийнхээ өргөдлийг өгөөд байна. “Хүннү коал” нь дээрх олборлолт явуулаагүй байгаа компаниудаас хамгийн түрүүнд олборлолтын үйл ажиллагаа явуулах боломжтой компани юм.

“Хүннү коал” компани нь одоогоор олборлолт явуулж эхлээгүй, ордыг ашиглах ТЭЗҮ нь хийгдэж байгаа тул тус компанийн ирээдүйд олох ашгийг тооцоолох, улмаар уг компанийн хувьцааны үнэ цаашид хэд хүрэхийг тооцоолоход эрт байна. “Хүннү коал” компани олборлолт явуулж эхлэхэд нүүрсний чанарын хувьд ижил, (хамгийн сүүлийн нүүрсний чанарын мэдээгээр) хамгийн төстэй олборлолт хийж байгаа компани нь “Саусгоби ресурс” байх болно гэж таамаглаж байна.

“Монголиан майнинг корпораци”, “Саусгоби ресурс” зэрэг олборлолт явуулж, нүүрсээ худалдаалдаг компаниудыг харьцуулалтын хүснэгтэд багтаасан. “Хүннү коал” компани олборлолт явуулж эхлэхэд эдгээр компаниудын жишгээр үнэлэгдэх бөгөөд энэ нь компанийн хувьцааг цаашид өсөх бүрэн боломжийг харуулж байна.

Уул уурхайн салбарын мэдээлэл

Ерөнхий

Нүүрсний хамгийн том хэрэглэгч болох Хятад улс дулааны болон коксжих нүүрсний хязгаарлагдмал нийлүүлэлттэй тулгараад байгаа нь манай улсын хувьд ашигтай байрлалд байгаа нүүрсний ордуудад ихээхэн боломжийг олгож байна. Үүний зэрэгцээ нүүрсний хамгийн том экспортлогч Австрали улс үерийн гамшигтай тулгарсан нь Монголын уул уурхайн компаниудад ашигтайгаар нөлөөлж байна. Өндөр чанарын нүүрс болон тээвэрлэлтийн хямд зардлыг анхаарч үзвэл Монголоос Хятад руу гаргаж байгаа экспортын хэмжээ ирээдүйд өсөх хандлагатай байна.

Хятадын нүүрсний зах зээл

Эрчим хүчний

Нүүрс нь эрчим хүчний үйлдвэрлэлд гол үүргийг гүйцэтгэж байгаа бөгөөд дэлхийн эрчим хүчний үйлдвэрлэлийн 41 хувийг бүрдүүлж байна. Олон Улсын Эрчим Хүчний Ассоциацийн мэдэгдсэнээр Хятадын эрчим хүчний гол эх үүсвэр нь нүүрс бөгөөд 79 хувийг эзэлж байна. Сүүлийн жилүүдэд эрчим хүчний нүүрсний нийлүүлэлт багасч байгаа үед металлургийн нүүрсний эрэлт ихсэх болсон байна. Жижиг болон үр ашиггүй үйл ажиллагаа явуулж байгаа уурхайнууд тогтмол хаагдах болсон нь Хятад улс нүүрсний нийлүүлэлтийн дутагдалд орж байгаагийн илрэл юм. Түүнчлэн эрчим хүчний нүүрсний импорт 2009 онтой харьцуулахад 191 хувиар өссөн байна. Бид Хятадын дотоодын нийлүүлэлт багассан, мөн Энэтхэг улсын нүүрсний эрэлт өсч байгаатай холбогдуулан эрчим хүчний нүүрсний эрэлт ихэсч, нүүрсний үнэ өндөр хэвээр байх болно гэж таамаглаж байна.

Австралийнх буурч, Монголынх өсчээ

Хятадын дулааны болон коксжих нүүрсний импорт 2009 онтой харьцуулахад 2010 онд эрс өссөн байна. 2010 онд Хятад улс 166,22 сая тонн нүүрс импортолсон бөгөөд энэ нь 2009 оныхоос 39,58 сая тонноор илүү юм. Харин коксжих нүүрсний импортын хэмжээ 12,78 сая тонноор өсч, 2010 онд 47,27 сая тонн болсон байна. Дэлхийн хамгийн том нүүрсний экспортлогч Австрали улс дэлхийн коксжих нүүрсний 54 хувийг нийлүүлдэг. 2009 онд Хятадын дулааны нүүрсний импортын 66 хувийг Австралийн нүүрс эзэлж байсан бол 2010 онд 37 хувь болж буурчээ. Харин Монгол улсын хувьд 2009 онд Хятадын коксжих нүүрсний импортын 12 хувийг эзэлж байсан бол 2010 онд ойролцоогоор 32 хувь болж нэмэгджээ.

Зураг 11: Австрали ба Монгол улсаас Хятад руу гаргаж байгаа коксжих нүүрсний экспортын хэмжээ

Экспорт-логч	2009 (сая.т)	2010 (сая.т)	Өөрчлөлт %	Зах зээлд эзлэх хувь 2009	Зах зээлд эзлэх хувь 2010	Өөрчлөлт %
Монгол	4.01	15.05	275%	12%	32%	167%
Австрали	22.72	17.38	-24%	66%	37%	-44%

Эх үүсвэр: McCloskey Coal Report, Issue 252, January 2011

Хэрэв та бүхэн коксжих нүүрсний зах зээлийн талаар илүү их судалгааг авахыг хүсвэл “Монголиан майнинг корпораци” хувьцааны судалгааг [ЭНД](#) дарж үзнэ үү.

Хавсралт 1: Компанийн удирдлага

<p>Матью Вүүд <i>ТУЗ-ын захирал</i></p>	<ul style="list-style-type: none"> • Бакалавр (Hons-Geology), Grad Certificate (Ашигт малтмалын эдийн засаг) • Нөөцийн салбарт 18 жил ажилласан туршлагатай, мөн төслийн ажлыг удирдан зохион байгуулах, гэрээ хэлэлцээр хийх, байгууллагын хөгжлийн чиглэлээр асар их туршлагатай.
<p>Жорж Төмөр <i>Ерөнхий Захирал</i></p>	<ul style="list-style-type: none"> • Магистр (Уул уурхай), Бакалавр (Металлург), Техникийн зэрэг (Ашигт малтмалын үйл ажиллагаа) • Монголын уул уурхайн компаниудад удирдах албан тушаал хашиж байсан бөгөөд үүний дотор Mongolian Mining Corporation-ын Ухаахудаг төслийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулсан • Уул уурхай, хууль эрх зүй, улс төрийн талаар арвин мэдлэгтэй
<p>Тимоти Флэвел <i>Гүйцэтгэх захирал/ Нарийн бичиг</i></p>	<ul style="list-style-type: none"> • Мэргэшсэн нягтлан бодогч, уул уурхай болон нягтлан бодохын чиглэлээр 20 гаруй жил ажилласан туршлагатай.
<p>Даниел Крэнан <i>Захирал</i></p>	<ul style="list-style-type: none"> • Компанийн тухай хууль, Худалдааны тухай хууль болон Оюуны өмчийн тухай хуулийн чиглэлээр мэргэшиж, Melbourne болон Perth-д өмгөөлөгчөөр ажиллаж байсан. • Австрали улсын Хуулийн зөвлөхийн нэрийн өмнөөс Нэгдсэн Байнгын Хороонд гэрээний дагуу хяналт тавьж байсан.
<p>Энгүс Кэйтнес <i>Санхүү Хариуцсан Захирал</i></p>	<ul style="list-style-type: none"> • Мэргэшсэн нягтлан бодогч, Australasia хүрээлэнгийн Санхүүгийн үйлчилгээний гишүүн, Ernst & Young-ын гүйцэтгэх захирал • BHP Billiton Ltd, Barrick Gold Corporation болон Woodside Petroleum Ltd зэрэг Олон улсын нийгэмлэгийн сангийн үйл ажиллагааны зөвлөх, итгэмжлэгчээр 10 гаруй жил ажилласан туршлагатай. • Түүнчлэн Лондонгийн хөрөнгийн бирж дээрх хөгжиж буй зах зээлтэй Kazakhmys Plc, Gem Diamonds Ltd, Hochschild Mining Plc болон Ferrous Resources Ltd зэрэг уул уурхайн компаниудын мэргэшсэн зөвлөх • LIndian Resources Limited компанийн захирал, Haranga Resources Limited компанийн ерөнхий нарийн бичиг.
<p>Батжаргал Цог <i>Үйл ажиллагаа эрхэлсэн захирал</i></p>	<ul style="list-style-type: none"> • Монгол улсын ШУТИС-ийн техникийн шинжлэх ухааны профессор, Тайланд дахь Азийн Технологийн Хүрээлэнгийн бакалавр. • Дэлхийн банкны UNDP болон AES-ийн Монгол дахь салбарын ерөнхий менежерийн үүргийг гүйцэтгэж байгаа бөгөөд эрчим хүчний салбарт 10 гаруй жил ажилласан туршлагатай. Түүнчлэн Монгол улс дахь эрчим хүч, дэд бүтцийг хөгжүүлэх төсөлд идэвхтэй оролцож байсан. Үүнд Mongolian Mining Corporation-ын Ухаахудаг төсөл, Тавантолгойн коксжих нүүрсний төслийн эрчим хүч болон дэд бүтцийн цогцолборыг улсын болон үйлдвэрлэлийн нөхцөлд тохируулан бүтээн байгуулах үйл ажиллагаа орно.
<p>Гансүх Төрмөнх <i>Тээвэр зохицуулалтын ерөнхий менежер</i></p>	<ul style="list-style-type: none"> • Монгол улсын Удирдлагын академийн төрийн удирдлагын магистр зэрэгтэй, Зам тээврийн их сургуулийг авто механик инженерийн мэргэжлээр Москва хотод төгссөн. • Монголын зам тээврийн салбарт 10 гаруй жил ажилласан туршлагатай, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Тээврийн газрын Зам тээврийн албаны дарга, түүнчлэн Монголын зам тээвэр хариуцсан Засгийн газар хоорондын үйл ажиллагааны хорооны нарийн бичиг.
<p>Чинбат Дүгэр <i>Үйл ажиллагаа хариуцсан ерөнхий менежер</i></p>	<ul style="list-style-type: none"> • Монгол улсын ШУТИС-ийн Уул уурхайн технологи мэргэжлээр бакалавр зэрэгтэй • Уул уурхайн салбарт 15 жилийн туршлагатай, ялангуяа коксжуулсан нүүрсний салбарт арвин туршлагатай бөгөөд Монголын хамгийн том нүүрсний уурхайн үйл ажиллагаа явуулдаг “Багануур” ХК-ийн Техник үйлчилгээний газарт ээлжийн хянагчаас эхлээд ерөнхий менежерийн үүргийг гүйцэтгэж ажилласан. • Мөн Mongolian Mining Corporation-д Уул уурхай геологийн албанд ерөнхий менежерээр ажиллаж, Ухаахудаг коксжуулсан нүүрсний төсөл дээр техник эдийн засгийн судалгааг гүйцэтгэсэн бөгөөд барилга байгууламж, олборлолтын үйл ажиллагаа явуулахад гол үүрэг гүйцэтгэж байсан.

МІСС-ЫН ТУХАЙ

Монголын Олон Улсын Хөрөнгийн Корпораци (МІСС) нь 2005 онд хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээ үзүүлэх зорилгоор байгуулагдсан. Монголын эдийн засгийн өнөөгийн эрчимтэй хөгжил болон санхүүгийн таатай орчин компаниудад хөрөнгө оруулалтын боломж, өсч хөгжих бодит бололцоо олгож байна. Үүнийг ашиглах боломжийг МІСС компани хөрөнгө оруулагчид болон харилцагчдадаа нээн өгч, хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээ, хөрөнгийн удирдлага, үнэт цаасны андеррайтер, брокерын үйлчилгээг үзүүлж байна. Үүнээс гадна Монголын макро эдийн засгийн судалгаа, дотоодын үйлдвэрлэлийн шинжилгээ болон Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй компаниудын талаарх тоймыг гаргаж байна. Бидний зорилго бол дотоодын болон олон улсын компаниудын стратегийн зорилгод нийцсэн, шинэлэг, үр ашигтай санхүүгийн хэлбэрийг сонгож, шаардлагатай хөрөнгө олж авахад нь дэмжлэг үзүүлэх явдал юм. Тийм ч учраас бид уул уурхай, үйлдвэрлэл, санхүү, худалдаа, агаарын тээвэр, барилгын салбаруудад үйл ажиллагаагаа явуулж буй тэргүүлэх компаниудтай удаан хугацаанд хамтран ажиллаж байна.

Холбоо барих хаяг:

Сентрал Таур, 9 давхар, 912 тоот, СБД-8, Улаанбаатар хот

Утас: 70112024, Факс: 70112025

Email: info@micc.mn

ТОДРУУЛГА

Уг судалгааг МІСС компанийн судалгааны шинжээчид бие даан бэлтгэсэн бөгөөд аливаа тухайлсан этгээдэд зориулагдаагүй болно. Энэхүү тайланд тусгагдсан аливаа таамаглал нь зөвхөн компанийн шинжээчдийн тооцоолол болно. Тайланд ашиглагдсан мэдээллийн үнэн зөвийг шинжээчид хариуцахгүй. Мөн энэхүү тайланд тусгагдсан үнэт цаастай холбоотой хөрөнгө оруулалтаас үүсч болзошгүй алдагдлыг Монголын Олон Улсын Хөрөнгийн Корпораци (МІСС) болон Компанийн (Хүннү коал) аль нь ч хариуцахгүй. Судалгаа хийж буй компанитай Монголын Олон Улсын Хөрөнгийн Корпораци хамтран ажиллахыг үгүйсгэхгүй ба уг компанийн захиалгаар судалгааны тайланг хийгээгүй болно.